6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,866,508.4	2,431,999.8	(4,434,508.6)

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 326,820.0 мянга, эцсийн үлдэгдэл 115,717.4 мянган төгрөг болж 211,102.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	326,820.0	115,717.4	(211,102.5)	100
Дүн	326,820.0	115,717.4	(211,102.5)	100

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 115,717.4 мянган төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд төсөвт байгууллагуудын буцааж төвлөрүүлсэн 14,618.7 мянга, орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 57,549.8 мянга, нийт 72,168.5 мянга,

Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 36,803.0 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 6,745.9 мянган төгрөг байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 315,546.0 мянга, эцсийн үлдэгдэл 304,638.8 мянган төгрөг болж 10,907.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл / мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	11,900.5	595.6	11,304.9	0%
Татаас, санхүүжилтийн авлага	184,586.5	0.0	184,586.5	0%
Байгууллагаас авах авлага	70,830.0	99,079.0	(28,249.0)	33%
Хувь хүмүүст олгосон зээл	48,229.0	204,964.2	(156,735.2)	67%
Дүн	315,546.0	304,638.8	10,907.1	100%

Эх сурвалж: Баянговь сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тус сумын нийт авлагын 67 хувийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 33 хувийг Орон нутгийн хөгжлийн сангийн малжуулах, өвс тэжээлийн авлага эзэлж байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	495.6	495.6	0.0	0%
ЗДТГ	744.9	100.0	644.9	0%
ЕБС	7,363.0	-	7,363.0	0%
ЭМТ	184,644.5	-	184,644.5	0%
Цэцэрлэг	2,647.9	-	2,647.9	0%
Соёл	671.0	-	671.0	0%
ОНХС	70,750.0	99,079.0	(28,329.0)	33%
СХС	48,229.0	204,964.2	(156,735.2)	67%
НИЙТ ДҮН	315,546.0	304,638.8	10,907.15	100%

Эх сурвалж: Баянговь сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 340,579.5 мянга, эцсийн үлдэгдэл 363,830.8 мянган төгрөг болж, 22,251.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	22,585.0	9,285.0	13,300.0	3%
Эм боох материал	4,678.2	-	4,678.2	0%
Дуусаагүй үйлдвэрлэл	25,000.0	-	25,000.0	0%
Бэлэн бүтээгдэхүүн	189.7	-	189.7	0%
Бичиг хэргийн материал	10,139.9	4,469.3	5,670.6	1%
Аж ахуйн материал	121,973.4	33,834.6	88,138.8	9%
Сэлбэг хэрэгсэл	40.0	-	40.0	0%
Түлш, шатах тослох материал	-	-	0.0	0%
Барилгын засварын материал	15,786.0	-	15,786.0	0%
Хүнсний материал	1,846.2	-	1,846.2	0%
Бусад хангамжийн материал	123,079.6	61,580.4	61,499.3	17%
Мал амьтад	15,261.5	15,261.5	0.0	4%
Нөөцийн бараа	-	238,400.0	-238,400.0	66%
Дүн	340,579.46	362,830.82	-22,251.4	100%

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл урьд оноос 22,251,4 мянган төгрөг буюу 35 хувиар өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний дуусгаагүй ажлыг нөөцийн бараа материал дансанд 238,400.0 мянган төгрөгөөр нэмж бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	4,561.0	4,613.5	(52.5)	1%
ЗДТГ	86,288.6	119,817.4	(33,528.8)	33%
ЕБС	104,343.2	-	104,343.2	0%
ЭМТ	42,930.8	-	42,930.8	0%
Цэцэрлэг	69,500.6	-	69,500.6	0%
Соёл	32,955.3	-	32,955.3	0%
ОНХС	-	238,400.0	(238,400.0)	66%
СХС	-	-	-	0%
НИЙТ ДҮН	340,579.5	362,830.8	-22,251.36	100%

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 345,419.8 мянган төгрөгийн бараа материалын 305,457.7 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 39,962.0 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн орлогоор бүртгэсэн, 65,890.0 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвүүд нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан оны эхэнд байсан 249,729.9 мянган төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн данс бүртгэлээс хассан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,673,926.1 мянга, эцсийн үлдэгдэл 3,064,756.7 мянган төгрөг болж, 4,609,169.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	7,607,146.1	3,039,038.7	4,568,107.4	1.0
Барилга байгууламж, орон сууц	5,812,544.2	1,867,920.5	3,944,623.7	61%
Тээврийн хэрэгсэл	282,810.0	281,630.0	1,180.0	9%
Машин тоног төхөөрөмж	670,796.1	274,573.8	396,222.3	9%
Тавилга эд хогшил	298,571.1	83,724.8	214,846.3	3%
Зам гүүрийн байгууламж	209,800.0	209,800.0	-	7%
Түүх соёлын дурсгалт зүйл	-	-	-	0%
Номын фонд	33,166.7	317.0	32,849.7	0%
Бусад үндсэн хөрөнгө	299,458.1	321,072.6	(21,614.5)	11%
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	66,780.0	25,718.0	41,062.0	100%
Программ хангамж	2,080.0	850.0	1,230.0	3%
Бусад биет бус хөрөнгө	64,700.0	24,868.0	39,832.0	97%
НИЙТ ДҮН	7,673,926.1	3,064,756.7	4,609,169.4	

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд сумын ЗДТГ нь 13,169.5 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 226,300.9 мянган төгрөгийн их засварын барилгын сайжруулалтаар бүртгэсэн ба сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвүүд нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан 4,847,479.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн данс бүртгэлээс хассанаас нийт хөрөнгө 4,609,169.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	17,056.3	17,906.3	(850.0)	1%
ЗДТГ	2,809,390.5	3,046,850.5	(237,460.0)	99%
ЕБС	1,623,880.1	-	1,623,880.1	0%
ЭМТ	619,327.6	-	619,327.6	0%
Цэцэрлэг	1,405,875.3	-	1,405,875.3	0%
Соёл	1,198,396.5	-	1,198,396.5	0%
ОНХС	-	-	-	0%
СХС	-	-	-	0%
НИЙТ ДҮН	7,673,926.1	3,064,756.7	4,609,169.41	100%

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 28,858.8 мянга, эцсийн үлдэгдэл 4,541.9 мянган төгрөг болж 24,316.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	6,419.1	1,791.9	4,627.2	39%
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	17,658.2	-	17,658.2	0%
Байгууллагад төлөх өглөг	4,431.6	2,700.0	1,731.6	59%
Хувь хүмүүст төлөх өглөг	350.0	50.0	300.0	1%
Дүн	28,858.8	4,541.9	24,316.9	1

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 4,541.9 мянган төгрөг байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангаас өмнөх оны байгууллагад төлөх 2,700.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, ЗДТГ-ын 1,791.9 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой, 50.0 мянган төгрөгийн хувь хүнд өгөх өглөгтэй гарснаас шалтгаалсан байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	46.3	-	46.3	0%
ЗДТГ	350.0	1,841.9	(1,491.9)	41%
ЕБС	562.2	-	562.2	0%
ЭМТ	22,907.9	-	22,907.9	0%
Цэцэрлэг	358.9	-	358.9	0%
Соёл	543.6	-	543.6	0%
ОНХС	2,700.0	2,700.0	-	59%
СХС	1,390.0	-	1,390.0	0%
НИЙТ ДҮН	28,858.8	4,541.9	24,316.92	100%

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,837,649.5 мянга, эцсийн үлдэгдэл 2,427,457.9 мянган төгрөг болж, 4,410,191.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эжний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,837,649.5	2,427,457.9	4,410,191.6	100%
Өмч: - төрийн	1,248,819.7	519,452.6	729,367.1	21%
Хуримлагдсан үр дүн	4,383,516.9	1,716,050.9	2,667,466.0	71%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,205,312.9	191,954.4	1,013,358.5	8%
Дүн	6,837,649.5	2,427,457.9	4,410,191.6	100%

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,427,457.8 мянган төгрөг болж 4,410,191.6 мянган төгрөгөөр буурсан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдлийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн, мөн шилжүүлсэн үнэдсэн хөрөнгөтэй холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний 1,013,358.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.4.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.15-ны өдрийн 4/19 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 246,100.0 мянга, татварын бус орлогыг 7,000.0 мянган төгрөгөөр /торгуулийн орлогыг 6,000.0 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,000.0 мянга/ нийт 254,300.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	247,300.0	298,575.9	52,307.7	121%
Хувь хүний орлогын албан татвар	133,000.0	204,555.0	71,555.0	154%
Үйл ажиллагааны орлого	20,000.0	17,323.5	(2,676.5)	87%
Хадгаламжийн хүү	27,000.0	15,824.1	(11,175.9)	59%
ҮХЭХ худалдсан борлуулсны албан татвар	4,000.0	1,481.5	(2,518.5)	37%
ҮХЭХ-ийн татвар	2,000.0	1,646.4	(353.6)	82%
Бууны албан татвар	1,800.0	2,070.0	270.0	115%
Тэмдэгтийн хураамж	2,000.0	3,200.1	1,200.1	160%
Газрын төлбөр	6,800.0	4,180.7	(2,619.3)	61%
ТТАМ ашигласны төлбөр	500.0	650.0	150.0	130%
Хүн амын унд, ахуйн хэрэглээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр	1,200.0	2,222.6	1,022.6	185%
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	15,000.0	13,476.4	(1,523.6)	90%
Малын тоо толгойн албан татвар	34,000.0	31,882.2	(2,117.8)	94%
бусад татвар		63.4	63.4	
Татварын бус орлого	7,000.0	4,211.5	(2,788.5)	60%
Торгуулийн орлого	6,000.0	3,011.5	(2,988.5)	50%
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	1,200.0	200.0	120%
Нийт дүн	254,300.0	302,787.4	49,519.2	

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 121 хувь буюу 52,307.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 71,555.0 мянга, бууны албан татвар 270.0 мянга, тэмдэгтийн хураамж 1,200.1 мянга, ус рашаан ашигласны орлого 1,022.6 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин хадгаламжийн хүүгийн орлого 11,175.9 мянга, малын тоо толгойн албан татвар 2,518.5 мянга, газрын төлбөр 2,619.3 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1,523.6 мянга, хүү торгуулийн орлого 2,988.5 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Баянговь сумын татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг татварын байцаагч 305,874.0 мянган төгрөг буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас 3,086.8 мянган төгрөгөөр илүү мэдээлж өмнө оны алдаа давтан гаргасан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлого орохоор төлөвлөснөөс 1.200.0 мянган төгрөг, сумын ОНХС-ийн үйл ажиллагааны орлого 4,680.0 мянган, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлт 8,772.4 мянган төгрөг орсон байна.

3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,628,442.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,524,732.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 487,123.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 628,564.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.15-ний өдрийн 4/19 дүгээр тогтоолоор нийт 1,750,257.5 мянган төгрөгийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.15-ний өдрийн 4/19 дугаар тогтоолоор анх 1,750,257.5 мянган төгрөг, сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.07-ны өдрийн 6/012 дугаар тогтоолоор 1,628,242.0 мянган төгрөг болгон 122,015.5 мянган төгрөгөөр бууруулан баталсан.

Эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилт 511,226.3 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 487,306.5 мянга, сумын орон нутгийн татварын болон татварын бус орлого 253,300.0 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,000.0 мянга, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 49,024.9 мянган төгрөг оруулахаар, урьд оны үлдэгдлээс 326,384.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.07-ны өдрийн 6/012 дугаар тогтоолоор төсвийн нийт зарлагыг 1,628,242.0 мянган төгрөг болгон 122,015.5 мянган төгрөгөөр бууруулсан нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 95,495.7 мянга, ОНХС-аас олгох дэмжлэгийг 19,380.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын гэрээт ажилчдын цалин, НДШ-ийг орон

нутгийн төсөвт баталсныг 2022 оны 5 сараас улсын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор аймгаас олгох санхүүгийн дэмжлэг буурсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 773,144.8 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилт 506,661.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 13,452.4 мянга, туслах үйл ажиллагааны орлого 1,622.1 мянга нийт 1,283,262.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 14,618.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,524,732.4 мянган төгрөг буюу 93,6 хувьтай байгаа нь ОНХС-аас хэрэгжүүлэн төсөл арга хэмжээг 35,886.0 мянга, Сум хөгжүүлэн сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүйгээс 46,563.5 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн, сумын Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 7,063.5 мянган төгрөгөөр дутуу олгосон зэргээс шалтгаалсан байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН-ын төсөвт төвлөрүүлсэн
ЗДТГ	416,118.4	415,797.0	321.4	99.9	521.4
ИТХ	75,201.1	71,326.2	3,874.9	94.8	3,874.9
ЕБСургууль	149,339.3	144,155.4	5,183.9	96.5	5,606.0
Цэцэрлэг	45,576.3	42,398.7	3,177.6	93.0	3,177.6
Эрүүл мэндийн төв	22,573.5	14,568.0	8,005.5	64.5	942.0
Соёлын төв	40,597.9	40,101.1	496.8	98.8	496.8
ОНХС	664,450.8	628,564.8	35,886.0	94.6	
Сум хөгжүүлэх сан	214,384.7	167,821.2	46,563.5	78.3	
Нийт дүн	1,628,242.0	1,524,732.4	103,509.6	93.6	14,618.70

Эх сурвалж: Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 10,891.2 мянган санхүүжилтийг олгож, зөөврийн компьютер, татварын пос машин, судалгааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянговь сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 05-ний өдөр ирүүлсэн байна.

Баянговь сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Б.Бат-Амгалан, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Б.Энхжаргал нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,404,356.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,043.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,830.5 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.03.09-ны өдөр ирүүлсэн.

1. Сумын ЗДТГ-ын даргын 2022.01.02-ны 01 дүгээр тушаалаар сумын Засаг даргын орлогч 1 орон тоогоор баталсан.

2.Тээврийн хэрэгсэл: Сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төвөөс бусад төсөвт байгууллагад тээврийн хэрэгсэл байхгүй байна.

3. Баянговь сумын ЗДТГ, ИТХ-аас тэтгэвэрт гарсан албан хаагч тайланд онд байхгүй бөгөөд тэтгэмж олгогдоогүй байна.

4. Орон нутгийн төсвөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.1, 13.13.2, 13.3.2 дахь заалтаар хориглосон хөрөнгө оруулалтын арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаар нийт 66,606.0 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн байна

Хүснэгт:Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

мян.төг

№	Зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл Урамшил	330,777.0	324,870.2	5,906.8
2	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,053.9	217,418.4	9,635.5
3	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	41,783.7	37,286.9	4,496.8
4	Бараа үйлчилгээний бусад зардал	256,299.4	209,732.5	46,566.9
	Нийт дүнгээр	855,914.0	789,308.0	66,606.0

5.1 Баянговь сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15.2.5¹ дах заалтыг зөрчин 1841.9 мянган төгрөгийн өглөгтэй гарсанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

6. Төсвийн байгууллагуудын албан хаагчдад байгууллагын төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах зорилгоор хамт олны хурлаар урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийг танилцуулах ажлыг зохион байгуулах, төсөвт байгууллагуудыг үргүй зардал гаргахгүй байхад анхаарч иргэд олон нийтэд хүргэх мэдээ, мэдээллийг цахимжуулах зайны сургалтыг зохион байгуулах олон нийтийн сүлжээг ашиглан сумын нэгдсэн группээр сурталчлах таниулах ажлыг зохион байгуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлэл нийт 145 мэдээлэл оруулсан. Хөрөнгө оруулалт худалдан авалтай холбоотой мэдээлэл 36, төсвийн гүйцэтгэл холбоотой 72 мэдээлэл, бусад мэдээлэл 37 байршуулан ажилласнаас хугацаандаа мэдээлсэн 68, хугацаа хоцорсон 76 мэдээлэл байна. Энэ нь 2022 оны 10 дугаар сард аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс шалгасан Шилэн дансны мэдээллийг шалгалтаар дутуу оруулсан мэдээллийг нөхөн оруулах чиглэл үүрэг өгөгдөж нэмж мэдээлэл оруулснаас хугацаа хоцорсон төлөвтэй харагдаж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитыг бүх төсөвт байгууллагуудыг хамруулан шалгасан ба мөн ОНО-ын гүйцэтгэлийг шалгаж дүнг жилийн эцсийн санхүүгийн тайлантай хамтатган танилцуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 12,618.7 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснийг Баянговь сумын Засаг даргын 2022.06.024-ны өдрийн 154 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

¹ хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;

Байхгүй.

4.7 Аудитын гол асуудал

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба ЭМТ, сургууль, цэцэрлэг, Соёлын байгууллагын орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 186,377.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 507.5 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 4,358.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 44,619.8 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 136,892.3 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

№	Байгууллага нэгжийн нэр	Аудитын төрөл	Алдаа зөрчлийн ангилал								Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн	
			Аудитаар өгсөн зөвлөмж		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга			
			Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/	Тоо	Дүн /төг/
1	Баянговь сумын ЗДТГ	Санхүү					1	1,835.0			1.00	1,835.0
		Нийцэл	1	1,841.9	1	44,619.8		-			2.00	46,461.7
2	Баянговь сумын ИТХ	Санхүү	1	4,000.0	0	-	0	-	0	-	1.00	4,000.0
		Нийцэл	0	-	0	-	0	-	0	-	-	-
3	Баянговь сумын Орон нутаг хөгжлийн сан	Санхүү	2	89,075.0	0	-	1	2,523.0	0	-	3.00	91,598.0
		Нийцэл		-				-			-	-
4	Баянговь сумын Сум хөгжүүлэх сан	Санхүү	1	41,975.4	0	-	0	-	1	507.5	2.00	42,482.9
		Нийцэл	0	-	0	-	0	-	0	-	-	-
Нийт		Санхүү	4	135,050.4	0	-	2	4,358.0	1	507.5	7	139,915.9
		Нийцэл	1	1,841.9	1	44,619.8	0	-	0	-	2	46,461.7
		Дүн	5	136,892.3	1	44,619.8	2	4,358.0	1	507.5	9	186,377.6

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,086.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 3,086.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

1.Илрүүлэлт:Баянговь сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сулаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 186,377.6 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь хэсэгт мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад жилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Илрүүлэлт: Баянговь сумын татварын орлогын мэдээг 305,874.0 мянган төгрөг буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас 3,086.8 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид орон нутгийн дансанд төвлөрсөн орлогын тайлан мэдээг Татварын хэлтэст үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

5.2 Албан шаардлага

Баянговь сумын Засаг даргын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ-аар батлуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засаг даргын тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ-аар батлуулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалттай нийцүүлэн тайлагнаж байх, мөн хуулийн 64.1.3-т заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 09 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянговь сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 86,377.6 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрсэн байна	1	0					1	0				
Баянговь сумын татварын орлогын мэдээг 305,874.0 мянган төгрөг буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас 3,086.8 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.	1	3,086.8					1	3,086.8				
Баянговь сумын Засаг даргын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ-аар батлуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж тайлагнаагүй	1	0			1	0						
Дүн	3	3,086.8			1	0	2	3,086.8				

---oOo---